

  
**ДҮНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар A/144

Мандалговь

“Гео зураглал” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/72 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сумын төвд 1км хатуу хучилттай авто зам болон явган хүний зам, гудамжны гэрэлтүүлгийн зураг, төсөв боловсруулах /Дэлгэрхангай сум/” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Гео зураглал” ХХК-тай 24,348,400 (хорин дөрвөн сая гурван зуун дөчин найман мянга дөрвөн зуу) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан ажлын даалгаврын дагуу Сумын төвд 1км хатуу хучилттай авто зам болон явган хүний зам, гудамжны гэрэлтүүлгийн зураг, төсөв боловсруулах ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Гео зураглал” ХХК-ны дэд захирал (Ж.Батнасан)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Дэлгэрхангай сумын Засаг дарга (М.Батсүх), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Л.ДОРЖБАТ

486210006